



**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ**

2019 оны 12 сарын 20 өдөр

Дугаар A/65

Улаанбаатар хот

Оны шилдэг алба, тасаг, баг, комисс, ажилтнуудыг  
шалгаруулж шагнах тухай

Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын Гурвын 3.3, 3.4 дэх хэсэг, Ерөнхий захирлын 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/64 дугаар тушаалаар байгуулагдсан Комиссын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус төвийн "Оны шилдэг алба, тасаг"-аар Донор зохион байгуулалтын тасгийг шалгаруулж цом, 1.000.000 /нэг сая/ төгрөгийн үнэ бүхий зүйлээр, "Оны шилдэг баг, комисс"-оор Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын зөвлөлийг шалгаруулж, цом, 300.000 /Гурван зуун мянган/ төгрөгийн үнэ бүхий зүйлээр, "Оны шилдэг ажилтан"-аар Чанар, цусны сонор сэрэмжийн албаны дарга Т.Алимаа, Технологийн тасгийн эрхлэгч Н.Халиун, Донор зохион байгуулалтын тасгийн сувилагч Э.Золбоо нарыг, "Оны шилдэг судлаач"-аар Чанар, цусны сонор сэрэмжийн албаны Чанарын менежер Э.Тунгалагтуяаг тус тус шалгаруулж, цом, 1 /нэг/ сарын албан тушаалын үндсэн цалингаар, "төвийн Ерөнхий захирлын нэрэмжит шагнал"-аар Нэгдсэн лабораторийн эрхлэгч М.Цэрэндэжид, Технологийн тасгийн Сувилагч Л.Өлзийбаяр нарыг шагнаж, цом, 1 сарын албан тушаалын үндсэн цалингийн 75 /далан таван/ хувиар, "Оны Ёс зүйг эрхэмлэгч ажилтан"-аар Сувилахуйн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Өнөрцэцэгийг шалгаруулж, цом, 100.000 /нэг зуун мянган/ төгрөгийн үнэ бүхий зүйлээр тус тус шагнаж урамшуулсугай.

2. Ажлын өндөр ачаалалтай ажиллаж, төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зөрчилгүй зохион байгуулсан Тендерийн үнэлгээний хороог 500.000 /таван зуун мянган/ төгрөгийн, жил, хагас жилийн байгууллагын эд хөрөнгийн тооллогыг чанартай зохион байгуулсан Тооллогын

080230

комиссыг 400.000 /дөрвөн зуун мянган/ төгрөгийн үнэ бүхий зүйлээр тус тус шагнасугай.

3. Шагналын мөнгийг цалин, урамшууллын зардлаас, өргөмжлөл, үнэ бүхий зүйлийг бусад зардлаас тооцон олгохыг Ахлах нягтлан бодогч /Ө.Бат-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор /Д.Амар/-т даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР